



ЭРҮҮГИЙН ХУУЛЬ ДАХЬ ШУДАРГА ЁСНЫ ЗАРЧМЫН ХЭРЭГЖИЛТ

*(Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйлийн 2.7 болон
12.3 дугаар зүйлийн 2.2 дахь хэсэгт заасан
зарим гэмт хэргийн жишээн дээр)*

БОДЛОГЫН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

Улаанбаатар хот
2020 он

ГҮЙЦЭТГЭГЧ: «Сайн туршлага» ТББ-ын ажилтнууд

БАГИЙН АХЛАГЧ:

МУИС-ийн ХЗС-ийн захирал, доктор (Ph.D) Ж.ЭРДЭНЭБУЛГАН

СУДЛААЧИД:

Өмгөөллийн «Кэй и партнерс» ХХН-ийн өмгөөлөгч Ж.БАТМӨНХ
ХНХЯ-ны Хуулийн асуудал хариуцсан ахлах шинжээч Д.РЕНЧИНДОРЖ
МҮХАҮТ-ын дэргэдэх Монголын Олон Улсын Арбитрын хуулийн
мэргэжилтэн Э.ЦЭЛМЭГ

«Сайн туршлага» ТББ нь эрх зүйн салбарт судалгаа эрхлэх, сургалт зохион байгуулах, төлбөрийн чадваргүй иргэдэд үнэ төлбөргүй хууль зүйн зөвлөгөө өгөх зорилготойгоор 2014 онд үүсгэн байгуулагдсан. Тус ТББ нь ННФ-ын дэмжлэгтэйгээр 3 дахь удаагийн бодлогын судалгаагаа танилцуулж байна.

© Нээлттэй Нийгэм Форум, 2020

Уг тайланг ашиглахдаа эх сурвалжийг дурдана уу.

ННА 67.408

ДАА 345

Э-739

ISBN: 978-9919-9645-0-4

Хаяг: Жамьян гүний гудамж

Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар-14240

Утас: 976-76113207

Факс: 976-11-324857

Вэб: <http://www.forum.mn>

И-мэйл: osf@forum.mn

ГАРЧИГ

| | |
|------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------|----|
| Удиртгал | 5 |
| Судлагдсан байдал | 8 |
| Судалгааны ач холбогдол | 10 |
| Судалгааны арга зүй | 10 |
| | |
| Нэг. Шударга ёсны зарчмын ойлголт, хандлага | 13 |
| | |
| Хоёр. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.1 дүгээр зүйлийн 2.7 болон 12.3 дугаар зүйлийн 2.3 дахь хэсэгт заасан гэмт хэргийн хэрэгжилт, үр нөлөө | 21 |
| | |
| Гурав. Гадаад улс орны шударга ёсны зарчим (<i>ne bis in idem</i>)-ын хэрэгжилт, онцлог, туршлага | 34 |
| | |
| Дүгнэлт | 40 |
| Санал | 41 |
| Ашигласан эх сурвалж | 42 |

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

| | |
|-------|-----------------------------------------|
| ЗГ | Засгийн газар |
| ТББ | Төрийн бус байгууллага |
| УДШ | Улсын дээд шүүх |
| УЕПГ | Улсын ерөнхий прокурорын газар |
| ҮХЦ | Үндсэн хуулийн цэц |
| ХЗДХЯ | Хууль зүй, дотоод хэргийн яам |
| ЦЕГ | Цагдаагийн ерөнхий газар |
| ШЕЗ | Шүүхийн ерөнхий зөвлөл |
| ШШГЕГ | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар |

УДИРТГАЛ

Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт «Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн» гэж заасан. Тиймээс төрийн үйл ажиллагаанд баримтлах «шударга ёсны зарчим» нь хүний эрх, эрх чөлөө, тэгш байдлыг хангах, тэдгээртэй харилцан шүтэлцэх тулгуур зарчим тул Монгол Улсын Эрүүгийн хуулийн¹ 1.3 дугаар зүйл дэх «шударга ёсны зарчим» дараах агуулгыг илэрхийлдэг. Үүнд:

1. Эрүүгийн хариуцлага нь тухайн хүн, хуулийн этгээдийн үйлдсэн гэмт хэрэг, түүний нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон байх шаардлагатай. Энэ нь ялын тогтолцоо, төрөл, ял оногдуулах, эрүүгийн хариуцлага, ялаас чөлөөлөх тухай хэм хэмжээнд тусгагддаг. Улмаар шүүх, шүүгч сэтгэл хөдлөлд автахгүйгээр үйлдэгдсэн гэмт хэргийн хор аюул, шүүгдэгчийн хувийн байдал, ялыг хөнгөрүүлэх болон хүндрүүлэх нөхцөл байдлыг тал бүрээс нь харгалзан алагчлахгүйгээр, эрх зүйн ухамсрыг удирдлага болгон үйлдсэн хэрэгт нь яв цав тохирсон ял оногдуулбал сая шударга ёсны зарчим хэрэгжиж байгаагийн нотолгоо болно². Аливаа шүүх харьяалах хэрэг маргаанаа хэний ч нөлөөнд авталгүйгээр зөвхөн бодитой нотлох баримтад үндэслэн хууль дээдэлж, хөндлөнгийн шууд, шууд бус оролцоогүйгээр шийдвэрлэж байгаа нь шударга ёсны зарчмын гол баталгаа хэмжүүр юм³.

¹ Эрүүгийн хууль (шинэчилсэн найруулга) Төрийн мэдээлэл сэтгүүлийн 2016 оны №7-д хэвлэгдсэн.

² С.Жанцан, Б.Бат-Эрдэнэ нар. «Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар», УБ, 2010 он, 46 дахь тал

³ Г.Совд нар, «Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар» УБ, 2000 он, 116 дахь тал

2. Манай улс Үндсэн хуулийнхаа 10 дугаар зүйлд зааснаар Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт⁴ болон Олон улсын Эрүүгийн шүүхийн Ромын дүрэм⁵-ийг соёрхон баталсан. Дээрх олон улсын эрх зүйн баримт бичигт тусгагдсан эрүүгийн хуулийн үндэс, суурь гол зарчмуудын нэг нь *ne bis in idem* буюу «нэг гэмт хэрэгт нэг л удаа ял шийтгүүлэх» юм. Олон улсын Эрүүгийн шүүхийн Ромын дүрмийн 20 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт «Ямар ч хүнийг 5 дугаар зүйлд дурдсан гэмт хэрэг үйлдсэнтэй холбогдуулж шүүхээс нэгэнт гэм буруутайг нь нотолсон буюу цагаатгасан бол түүнд өөр шүүхээс ял оногдуулж болохгүй», Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 14 дүгээр зүйлийн 7 дахь хэсэгт «Үйлдсэн гэмт хэрэгтээ тухайн орны хууль болон эрүүгийн байцаан шийтгэх хуулийн дагуу эцэслэн шийтгүүлсэн буюу цагаатгагдсан хэнийг ч тэрхүү гэмт хэргээр нь дахин шүүх буюу шийтгэх ёсгүй» хэмээн уг зарчмын агуулгыг тодорхойлсон байдаг.

Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар биелүүлэх, дотоодын хууль тогтоомжийг олон улсын конвенцод нийцүүлэх шаардлагын хүрээнд уг зарчмын агуулгыг Эрүүгийн хуульд шинэчлэн тусгасан билээ. Тухайлбал, Монгол Улсын 2015 оны Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалд «шударга ёсны зарчим»-ыг дараах байдлаар томъёолсон. Үүнд:

«Үндсэн хуулиар тунхагласан үнэт зүйлсийг Эрүүгийн хуулиар бүрэн хамгаалж чадаагүй, даяарчлагдаж буй эрин үед олон улсын нийтийн эрх зүйн хөгжлөөс хоцрох хандлагатай байна. Тиймээс Эрүүгийн хуулийн⁶ ерөнхий ангид:

1. Ерөнхий ангид нэрлэж томъёолсон зарчмуудын агуулгыг Олон улсын Эрүүгийн шүүхийн Ромын дүрэмд заасан

⁴ Монгол Улс 1974 оны 11 сарын 18-нд соёрхон баталсан.

⁵ Монгол Улс 2002 оны 04 сарын 05-нд соёрхон баталсан.

⁶ Анх хууль санаачлагч нар Гэмт хэргийн тухай хууль гэж нэрлэж байсан.

агуулгаар шинээр томъёолж, боловсруулна. Ингэснээр шүүх хуульд заасан зарчмыг баримталж хэрэг шийдвэрлэх боломж бүрдэнэ гэж үзэж байна. Тухайлбал, *nullum crimen sine lege, ne bis in idem* гэсэн олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмыг хууль ёсны болон шударга ёсны зарчимд тусгаж, бэлгийн болон хүйсийн чиг баримжаа, илэрхийллээр ял оногдуулахад ялгаварлахгүй байх, нэг гэмт хэрэгт нэг удаа ял оногдуулах, халдаан хэрэглэхгүй байх талаар заана.

2. Онц аюултай гэмт хэрэгтэн, ялтай байдал, урьд ял шийтгүүлсэн, гэмт хэрэг давтан үйлдсэн гэж хүндрүүлэн үзэхээр нэрлэн заасан, хууль зүйн үр дагавар үүсгэдэг ойлголтыг өөрчилж, Тусгай ангийн хүндрүүлэх бүрэлдэхүүн болгон авч үзэхгүй байхаар хуулийн төсөлд тусгана. Эрүүгийн хуулийн нийт 49 зүйлд давтан, 13 зүйлд урьд ял шийтгүүлсэн бол хүндрүүлж үзэхээр заасан. Энэ нь нэг гэмт хэрэгт нэг удаа ял шийтгэх буюу олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмыг гажуудуулахад хүргэж, аливаа гэмт хэрэгт ял шийтгүүлж, эдэлсний дараа түүний үр дагаврыг хүндрүүлэн хэрэглэж байгааг өөрчилнө».

Гэтэл 2015 онд Монгол Улсын Их Хурлаас Эрүүгийн хуулийг шинэчлэн найруулж батлахдаа Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12 дугаар бүлэг буюу Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэргийн 12.1 дүгээр зүйл (Хүчиндэх)-ийн 2 дахь хэсгийн 2.7 болон 12.3 дугаар зүйл (Бэлгийн мөлжлөг)-ийн 2 дахь хэсгийн 2.2-т «урьд нь энэ бүлэгт заасан гэмт хэрэг үйлдэж гэм буруутайд тооцогдож байсан хүн» гэсэн заалтыг оруулж баталсан. Энэ нь (1) хүчиндэх болон (2) бэлгийн мөлжлөг гэсэн хоёр гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүн бөгөөд хүнийг өмнө нь үйлдсэн гэмт хэргийн төлөө дахин хариуцлага хүлээлгэхээр хуульчилсныг харуулж байна. Дээрх хоёр гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүнд «урьд нь энэ бүлэгт заасан гэмт хэрэг үйлдэж гэм буруутайд тооцогдож байсан хүн» гэж тусгасан нь хуулийн үзэл баримтлал, нэр томъёо, олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмаас гажжээ. Үүний улмаас хүн нийгэмд онц аюултай гэмт хэрэгтэн,

ялтай этгээд, урьд нь ял шийтгүүлсэн этгээд, хүчиндэгч гэх мэтээр дахин дуудагдах, хүний өмнө нь үйлдсэн гэмт хэргийн үр дагавраар эрүүгийн хариуцлагыг хүндрүүлж, эрх зүйн байдлыг дордуулж байна. Энэ нь Эрүүгийн хуульд тусгалаа олсон *ne bis in idem*-ын агуулгатай зөрчилдөхөөр байгаа юм. Өөрөөр хэлбэл, тухайлсан аль ч гэмт хэргийн хувьд *ne bis in idem* зарчим ялгамжгүйгээр үйлчлэх ёстой билээ. Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүгийн хуульд тусгагдсан зарчим зарим төрлийн гэмт хэрэгт үйлчилдэггүй буюу ялгаатай байж болохгүй юм.

Практик судалгаанаас үзэхэд, 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа шинэчилсэн Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.1 дүгээр зүйлийн 2.7 дахь хэсэгт заасан гэмт хэргээр одоогийн байдлаар 9 хүн ял шийтгэгджээ⁷. Өөрөөр хэлбэл, энэ хүмүүсийн хувьд эрүүгийн хуулийн шударга ёсны зарчим бүрэн агуулгаараа хэрэгжээгүй болохыг илтгэж байна.

Иймд хөндлөнгийн судлаачдын байр сууриас эрүүгийн хуулийн шударга ёсны зарчмын агуулга, бусад улсын туршлага, чиг хандлага, эрүүгийн хуульд тусгагдсан байдал, үр дагавар, практик хэрэгжилтийг Эрүүгийн хуулийн тусгай ангид тусгагдсан дээрх хоёр гэмт хэргийн жишээн дээр харьцуулан судалж, энэ талаар хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай эсэхэд судалгааны санал, дүгнэлт гаргахыг зорилоо.

Судлагдсан байдал

Монгол Улс 1924 онд анхдугаар Үндсэн хуулиа баталсны дараа эрүүгийн хуулийг 1926 онд Шүүх цаазын бичиг нэртэйгээр баталж улмаар нийт зургаан удаа шинэчлэн баталж, хэрэгжүүлсэн⁸ бөгөөд гэмт хэрэг давтан үйлдэх, урьд ял шийтгүүлсэн этгээдэд эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэн авч үзэж ирсэн уламжлалтай⁹. Харин Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, Олон улсын Эрүүгийн шүүхийн Ромын дүрэм зэрэг олон улсын гэрээг

⁷ <http://new.shuukh.mn/eruuhanhan>

⁸ <https://mojha.gov.mn/newmojha/?p=556>

⁹ 1986, 2002 онуудын Эрүүгийн хуульд гэмт хэрэг давтан үйлдэх ойлголтыг тусган, хариуцлагыг хүндрүүлэн авч үзсэн байна.

Монгол Улс соёрхон баталснаар эрүүгийн эрх зүйн «шударга ёс»-ны зарчмын агуулгыг шинээр авч үзэх шаардлага зүй ёсоор тавигдах болсон. Өмнө дурдсан судалгаа, эрдэм шинжилгээний өгүүлэлд гэмт хэрэг давтан үйлдэх, гэмт хэргийн хүндрүүлэх нөхцөл байдал, онц аюултай рецидив гэмт хэрэгтэн зэрэг ойлголтыг нарийвчлан авч үзэж, улмаар боловсронгуй болгох агуулгаар холбогдох бүтээлд тусгасан байна. Харин олон улсын нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн *ne bis in idem* зарчмын үүднээс гэмт хэрэг давтан үйлдэх явдлыг Эрүүгийн хуулийн тусгай ангид хүндрүүлэн ял шийтгэл оногдуулах байдлаар тусгасныг тусгайлан судалсан бүтээл байхгүй байх бөгөөд эрүүгийн эрх зүйн зарим бүтээлд дурдагдах төдий оржээ.

Харин Хууль зүй дотоод хэргийн яам (2012-2016)-аас боловсруулсан Гэмт хэргийн тухай хуулийн үзэл баримтлал, танилцуулгад нэг гэмт хэрэгт нэг удаа ял ногдуулах зарчмын агуулга тодорхой тусгагдсан байгаа нь Эрүүгийн хуулийн шинэчлэлийн хүрээнд олон улсын туршлага, зарчмыг хүлээн зөвшөөрч буйн илрэл гэж үзэж болох юм. Гэвч нөгөө талаас, тодорхой төрлийн гэмт хэрэгт уг үзэл баримтлалыг бүрэн тусгаагүй, орхигдуулсан нь хуулийн төсөл боловсруулах, хууль санаачлах, батлах үйл ажиллагааны алдаа юм.

Судалгааны зорилго

Энэхүү судалгааны зорилго нь Эрүүгийн хуульд туссан *ne bis in idem* зарчим Монгол Улсад хангалттай хэрэгжиж байгаа эсэхийг тодорхой гэмт хэргийн жишээн дээр судалж дүгнэлт хийх, энэ талаар санал, зөвлөмж боловсруулан судлаачид олон нийтийн анхаарлыг энэ асуудалд хандуулахад оршино.

Судалгааны зорилт

Судалгааны багийн хувьд дээрх судалгааны ажлын үндсэн зорилгод хүрэх үүднээс дараах зорилтуудыг баримталж ажиллалаа. Үүнд:

- Шударга ёсны зарчмын талаар ойлголт, агуулгыг тодорхойлох;
- Шударга ёс, нэг гэмт хэрэгт нэг удаа ял оногдуулах зарчмын

- талаар гадаад орнуудын эрх зүйн зохицуулалт, чиг хандлага, туршлагыг судлах;
- Олон улсын эрх зүйн баримт бичиг болон Монгол Улсын хууль тогтоомжид *ne bis in idem* зарчим хэрхэн тусгагдсан талаар дүн шинжилгээ хийх;
 - Хүчиндэх болон бэлгийн мөлжлөгийн эсрэг гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүнийг судалж, хуульд уг агуулгаар тусгах хэрэгцээ шаардлага, тус зарчимд нийцэж буй эсэхийг тодорхойлох;
 - Цаашид дээрх гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүнд зохистой нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага байгаа эсэхийг судалж санал, зөвлөмж гаргах зэрэг болно.

Судалгааны ач холбогдол

Ne bis in idem зарчим нь олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим болохын хувьд тухайн улсын Үндсэн хууль болоод салбар хуулиуд, ялангуяа Эрүүгийн хуулийн хэм хэмжээнд тусгагдан, үндсэн суурь үзэл баримтлал болох учиртай. Тиймээс зарчмын хэрэгжилтийг тодорхой гэмт хэргийн жишээн дээр судалж, дүгнэснээр хууль тогтоогч, иргэний нийгмийн байгууллага, олон нийт тус зарчмын талаарх ойлголт, хандлагыг танин мэдэж, энэ судалгаанд иш татсан гэмт хэрэгтэй холбоотойгоор Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай эсэхийг тодорхойлох, улмаар энэ асуудалд судлаачдын анхаарлыг хандуулахад оршино.

Судалгааны арга зүй

Хэдийгээр 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хэрэгжиж буй Хууль тогтоомжийн тухай хуулиар хууль тогтоомжийг Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан зарчмаас гадна судалгаа, шинжилгээнд үндэслэсэн байх зарчмыг баримталж, боловсруулахаар заасан хэдий ч Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулга нь бүхэлдээ нарийвчилсан судалгаа, шинжилгээнд үндэслэсэн эсэх нь судлаач эрдэмтэд төдийгүй

олон нийтийн дунд ч эргэлзээ үүсгэж байна. Тэдгээрийн нэг нь уг судалгааны хүрээнд авч үзэж буй гэмт хэргүүдэд *ne bis in idem* зарчимтай зөрчилдсөн байдлаар хуульчилсан байдал юм. Судлаачид судалгааны ажлын үндсэн зорилго, түүнд хүрэхээр дэвшүүлсэн зорилгод хүрэхийн тулд дараах арга, аргачлалыг ашигласан болно.

Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.1 дүгээр зүйлийн 2.7 дахь хэсэг болон 12.3 дугаар зүйлийн 2.2 дахь заалтаар ял шийтгэгдсэн хүмүүсийн талаарх шүүхийн шийдвэрүүдийг сонгон авч хэрхэн шийдвэрлэгдсэн байдалд дүн шинжилгээ хийлээ.

Судалгаанд холбогдох баримт бичгүүдийг дараах ангилалд оруулан дүн шинжилгээ хийв. Үүнд:

1. Шударга ёсны зарчмын талаар судалгаа, шинжилгээ хийсэн дотоод, гадаадын эрдэмтэн, судлаачдын үзэл баримтлал, байр суурь, судалгааны бүтээл, олон улсын хэм хэмжээ, хуулийн үзэл баримтлалыг тухайлан авч үзлээ.
2. Эрх зүйн орчны хүрээнд *ne bis in idem* зарчим Үндсэн хууль болон Эрүүгийн хуульд хэрхэн тусгагдсан талаар дүгнэлт хийж, Эрүүгийн хуулийн хувийн хэргийг судаллаа.
3. Шударга ёсны зарчимтай холбоотой Үндсэн хуулийн цэцийн шийдвэр болон Үндсэн хуулийн цэцэд маргаан үүссэн мэдээллийн үндэслэлд дүн шинжилгээ хийв.
4. Статистик мэдээлэлд дүн шинжилгээ хийсэн бөгөөд энэ хүрээнд 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хойш дээрх гэмт хэрэг үйлдэж ял шийтгэгдсэн хүмүүсийн талаар тоон мэдээллийг нарийвчлан авч үзлээ.

Тэрчлэн, шударга ёсны зарчим хэрхэн хэрэгждэг талаарх гадаад улсын туршлага, эрх зүйн орчныг харьцуулан судаллаа. Харьцуулан судлах хүрээнд манай улстай эрх зүйн тогтолцооны хувьд ойролцоо, эрүүгийн эрх зүйн хөгжил өндөр улс орнуудтай, тодруулбал ХБНГУ, ОХУ, Франц зэрэг улсын хууль тогтоомжийг судаллаа. Ингэхдээ макро болон микро харьцуулалтыг тогтолцоо, үр нөлөөнийх нь хувьд авч үзэв. Тухайлбал, ОХУ 2003 онд Эрүүгийн хуулиас давтан гэх ойлголтыг хасах болсон үндэслэлээ

тайлбарлахдаа гэмт этгээд нэг зүйл, нэг хэсэгт заасан гэмт хэргийг хоёр буюу түүнээс дээш удаа үйлдэнэ гэж тодорхойлох нь учир дутагдалтай гэж үзжээ. Энэ нь юуны өмнө Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт, түүнчлэн Үндсэн хууль, Эрүүгийн хуульд заасан шударга ёсны зарчимтай зөрчилдөнө. Тодруулбал, гэмт хэрэг үйлдсэн этгээдэд тухайн гэмт хэрэгт нь зөвхөн нэг удаа эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ гэсэн үндсэн зарчмын агуулгатай холбон үзжээ¹⁰.

Хууль зүй, дотоод хэргийн яам, Улсын ерөнхий прокурорын газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, Шүүхийн ерөнхий зөвлөлийн судалгаа, мэдээллийн ажилтнууд болон уг сэдвээр судалгаа, шинжилгээ эрхлэн явуулдаг судлаач, эрдэмтэд, багш нартай мэдээлэл цуглуулах, судалгааны хүлээн зөвшөөрөгдөх байдлыг нэмэгдүүлэх зорилгоор ганцаарчилсан уулзалт, ярилцлага хийлээ. Түүнчлэн, Монголын хуульчдын холбооны Эрүүгийн эрх зүйн хорооны гишүүн хуульчдын үзэл, хандлагыг танин мэдэх зорилгоор тэднээс анкетын аргаар судалгаа авсан болно.

Уг судалгааг Нээлттэй Нийгэм Форумын (ННФ) судалгааны тэтгэлгийн дэмжлэгтэйгээр хийж гүйцэтгэсэн бөгөөд уг судалгаагаар боловсруулсан санал, зөвлөмж нь гагцхүү судалгааны үр дүн, судлаачдын итгэл үнэмшилд тулгуурласан болно.

¹⁰ Э.Батбаяр «Ял хүндрүүлэх тухай маргааны зарим асуудалд» өгүүлэл 2 дахь талд, <http://legaldata.mn/buteel/pdf?id=66>

НЭГ. ШУДАРГА ЁСНЫ ЗАРЧМЫН ОЙЛГОЛТ, ХАНДЛАГА

«Шударга байх», «шударга ёс» гэсэн ойлголтын гарал үүсэл нь латины *Jus, Justitia* буюу «тэнцвэртэй, зохистой буюу үнэн зөв, тогтвортой» гэсэн утгыг илэрхийлж иржээ. Шударга ёсны философи, танин мэдэхүйн үндэслэл нь Эртний Грекийн нэрт сэтгэгч Платон, Аристотель нарын сургаалд тусгалаа олсон байдаг. Платон «Шударга байх гэдэг нь хамгийн энгийнээр хэлбэл хэн ч бусдын юмыг авахгүй, мөн өөрийнхөө юмыг алдахгүй байх явдал» гэсэн нь бий. Тэрээр «Хүчтэй эрх мэдэлтэй шилдэг төр хийгээд тогтвортой ухаалаг шилдэг хуулиудтай байх нь ариун дээд шударга ёсны оргил нь болдог» тухай сургаж байжээ. Харин Аристотель эрх зүй нь шударга ёстой салшгүй холбоотой харьцангуй тогтвортой байх онцлогийг нээн илрүүлж, шударга байх шаардлага нь ёс зүйн хэм хэмжээ болж зохистой, сайн үйлийн илрэл болон хөгжих учиртайг тэмдэглэн бичжээ. Тэрээр шударга ёсны үйлчлэх орон зайг эрх зүйн оршин амьдрах цаг үе, орчинтой холбон өргөн хүрээнд тайлбарлахыг оролдож, шударга ёс хийгээд тэгш эрхийн хоорондын хамаарлыг олж харсан байдаг.

Харин эртний Ромын нэрт хуульч Ульпиан, Павла, Цицерон нар шударга ёсны эрх зүйн үндэслэлийг анхлан томьёолсон сэтгэгчдийн гол төлөөлөл юм. «Бусдад хохирол учруулахгүйгээр өөрийгөө болон өөрийн үйлдлээ хариуцах явдал нь шударга ёс» гэж Ульпиан хэлсэн бол «Хаана эрх зүй тогтооно, тэнд шударга ёс ноёлно», «Хуулиудаас шударга ёс үүсэхгүй, харин шударга ёсноос хуулиуд үүснэ» гэж Павла, Цицерон нар номлосон. Үүнээс шударга ёс нь хүний эрх, эрх чөлөөтэй салшгүй холбоотой жам ёсны эрх зүйн чухал үнэт зүйлс болох нь харагддаг. Үүний дараах Дж.Локк, И.Кант нарын дэвшүүлж байсан хязгаарлагдсан эрх чөлөөний ухамсарлагдсан зайлшгүй байдал нь шударга ёсны зүй тогтолт шинж нь болдог. Тэдний үзлээр «Ямар ч хүний эдлэх эрх, эрх чөлөө нь бусдын

эрхээр хязгаарлагдана. Хэн боловч өөрийн хүсэл сонирхол, эрх чөлөөг эдлэхдээ бусад хүний эрхэнд халдахгүй, түүнийг хөндөхгүй байх» тухай сургасан. Шударга ёс нь ёс зүйн төдийгүй улс төр, эдийн засаг, эрх зүйн шалгуураар хэмжигдэж, нийгмийн хөгжлийн хүчин зүйл болдог учраас түүний үнэлэмж нь зарим талаар хувьсамтгай тогтворгүй байх нь бий.

Харин Ж.Роулс шударга ёс нь тэгш эрхийг үгүйсгэх ба зөвшөөрөх ялгагдах зарчмуудыг өөртөө агуулж, эрх чөлөөт боломжийн хязгаарлагдах хийгээд нөхөгдөх шаардлага, хэм хэмжээг тусган харьцангуй тогтвортой үнэлэмж, үнэт зүйлс болж оршдог гэжээ. Эрх зүй ба шударга ёсны харилцан холбогдох шинж нь дараах байдлаар илэрнэ. Үүнд:

- Шударга ёс нь эрх зүйн үйлчлэх боломжийг хангаж, түүний зохицуулалтын чухал зарчим болно.
- Эрх зүй нь шударга ёсны шалгуур болох бөгөөд эрх зүйд амьдарч, улмаар нийгмийн бодит байдал болж төлөвших үед шударга ёс биеллээ олж, тогтвортой байх нөхцөл нь бүрдэнэ.
- Шударга ёс нь эрх чөлөө, тэгш эрх, хууль ёсны нэгдмэл байдлыг хангаж, тэдгээрийг холбох гол хөшүүрэг нь болно.
- Эрх зүй, шударга ёсны харилцан холбогдол нь ёс зүйн үнэлэмж болон харьцангуй тэнцлийн зарчмыг аяндаа бий болгон эрх зүйн нөлөөллийг үүсгэн нөхцөлдүүлж байдаг.

Түүхэн хөгжлийн янз бүрийн цаг үед шударга ёсны шалгуур, үнэт зүйлс өөрчлөгдөн шинэчлэгдэж, хөгжсөөр иржээ. Гэхдээ шударга ёс нь эрх чөлөө, тэгш эрх, ёс суртахуунтай холбогдож, үнэт зүйлсийн зөв зохистой байдлыг агуулдгаараа эрх зүйтэй илүү хамааралтай, түүний салшгүй эд эс нь болсон байна¹¹. Шударга ёсыг хэрэгжүүлдэг үндсэн арга бол аливаад алагчлалгүй хандаж шийдвэрлэх явдал юм¹².

Эдүгээ шударга ёс бол нэгэнт батлагдсан хуулиа чанд сахиулах тогтолцоог бүрэлдүүлж, хүн амын эмзэг давхаргын амьжиргааны

¹¹ Д.Баярсайхан. Эрх зүйн онол. УБ., 2010 он. 39-42 дахь тал

¹² Г.Совд, Н.Жанцан. Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар. УБ., 2000 он. 27 дахь тал

доод түвшнийг баталгаажуулах замаар ядуурлыг бууруулах, улс орныхоо эдийн засгийн болон оюуны бололцооны хэрээр Үндсэн хуулиар бататгасан эрх, эрх чөлөөг иргэн бүхэнд адилхан эдлүүлэх бодлого явуулан хэрэгжүүлэх, үүний хамт хүн бүр хууль зүйн дагуух үйл ажиллагаагаараа бий болгож, өвлөж эзэмшиж буй өмч хөрөнгийнхөө хэмжээ, бусдад ба нийт нийгэмд зориулж гүйцэтгэсэн хөдөлмөрийнхөө тоо чанар, хувийн авьяас билгийн зохистой өгөөж зэргийнхээ ачаар нийгмийн баялгаас хүртэх арга ба тэр хэмжээгээрээ, өөрийгөө олон талаар хөгжүүлэх бололцоогоор зохистой ялгарах нөхцөлийг эдийн засаг, улс төр, хууль зүй, ёс суртахууны үүднээс бүрдүүлэхэд оршино. Шударга ёсны зарчим, үзэл санаа нь хувь хүн хичээл зүтгэлээрээ өөрийн орших ахуйг бүтээж, нийгэм нь хүмүүнлэг нөхцөлийг бүрдүүлснээр өөрийн үндсийг бататгах зарчмын хүрээнд хэрэгжинэ¹³.

Төрийн эрх мэдлийг хэрэгжүүлэгч бүх байгууллага, албан тушаалтан үйл ажиллагаандаа шударга ёсны зарчмыг удирдлага болгох ёстой. Өнөө үед ч гэсэн шударга ёсонд харш үйл ажиллагаа болох өмч хувьчлалын явцад гарсан гажуудал, авлигад автах, хээл хахууль авч өгөлцөх, нийгэм иргэдийн ашиг сонирхлыг хохироож, гэмт хэрэг, зөрчил үйлдсэн хүмүүст хууль зүйн зохих хариуцлага хүлээлгэхгүй ял зэмлэл завшуулах, эрх зүйн зохицуулалтад хийдэл гарах, хууль хяналтын байгууллагын үйл ажиллагаа хангалтгүй байгаа билээ. Манай улс Үндсэн хуулиараа төрийн үйл ажиллагааны үндсэн зарчмын нэг нь шударга ёс болохыг заасан. Тэгвэл төрийн шударга ёс нь төрөөс иргэний өмнө хүлээх үүрэг хариуцлагаар тодорхойлогдоно. Хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлж буй бүх байгууллага, албан тушаалтны үйл ажиллагаа шударга ёсонд нийцсэн байж нийгэм эрүүл саруул оршин хөгжих нөхцөл бүрдэнэ¹⁴. Шударга ёсны зарчим нь олон улсын эрх зүйн нэгэн зарчим төдийгүй нийгмийн үйл ажиллагааг үнэлсэн ёс суртахуун – эрх зүйн ба нийгэм, улс төрийн ухамсрын философийн категори юм¹⁵.

¹³ Ч.Энхбаатар. Үндсэн хуулийн эрх зүй. УБ., 2007 он. 119 дэх тал

¹⁴ Д.Лүндээжанцан, Ч.Энхбаатар нар. Монгол Улсын Үндсэн хуулийн эрх зүй. УБ., 2000 он. 118-121 дэх тал

¹⁵ С.Нарангэрэл. Эрх зүйн эх толь бичиг. УБ., 2007 он. 594 дэх тал

Мөн шударга ёс нь Эрүүгийн эрх зүйн зарчим болохын хувьд эрүүгийн хуулийн шударга байдал, шүүгдэгчид оногдуулж буй ял оновчтой, шударга байхын бодит илэрхийлэл билээ. Эрүүгийн шударга хууль нь олон түмний хүндэтгэл, дэмжлэгийг хүлээсэн байдаг. Өөрөөр хэлбэл, эрүүгийн хуульд хүн, нийгэм, төр, байгууллага, аж ахуйн нэгжийн эрх ашиг сонирхолд хохирол учруулахуйц аюултай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцсон, хэм хэмжээ нь нийгэм, эдийн засаг, эрх зүйн хувьд хангалттай үндэслэлтэй, амьдралын шаардлагад бүрэн нийцсэн байвал сая шударга сайн хууль болно. Амьдралын бодит шаардлагад нийцээгүй эрүүгийн хууль нь нийгмийн эрх зүйн ухамсрын тусгал болохгүй, тэдний ашиг сонирхлыг хамгаалж чадахгүйд хүрнэ.

Хэрэв эрүүгийн хууль нь хамгаалах болон урьдчилан сэргийлэх чиг үүрэг тэрчлэн иргэн, нийгмийг гэмт халдлагаас хамгаалах, гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цээрлүүлэх, хүмүүжүүлэх, бусад хүмүүсийг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилтыг амжилттай хэрэгжүүлж байгаа бол нийгмийн хувьд хэрэгцээ, шаардлагад нийцсэн үндэслэл сайтай, шударгад тооцогдоно. Нийгэмд аюултай үйлдэл, эс үйлдэхүйг гэмт хэрэгт тооцож эрүүлжүүлээгүй өөрөөр хэлбэл, хийдэл ихтэй хууль нь шударга ёсны зарчимтай илт зөрчилддөг бөгөөд иргэн, нийгмийн чухал эрх ашиг, сонирхол эрүүгийн хамгаалалтын гадна үлдсэн байдаг. Эрүүгийн хуульд заасан ялын шударга байх зарчим нь ялын тогтолцоо, төрөл, ял оногдуулах, эрүүгийн хариуцлага, ялаас чөлөөлөх тухай хэм хэмжээнд биеллээ олдог. Нэг буюу төсөөтэй гэмт хэрэг үйлдсэн, хувийн байдлаараа янз бүрийн хүмүүст болон янз бүрийн гэмт хэрэг үйлдсэн боловч хувийн байдлын хувьд ижил хүмүүст нэг төрөл, хэмжээний ял хэрэглэхийн аль аль нь шударга ёсны зарчимд харш юм. Өөрөөр хэлбэл, Эрүүгийн хуулийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд нэг талаас гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулж байгаа хариуцлагын төрөл, хэмжээ нь түүний үйлдсэн хэргийн нийгмийн хор аюулын шинж чанар, уг этгээдийн хувийн байдал болон түүний үйлдлийг зүйлчилсэн хуулийн зүйл ангийн заалт зэрэгт хөдөлбөргүй тохирсон байхын хамт, хууль хэрэглэгч мөрдөгч, шүүгчийн зүгээс уг этгээдэд алагчлах үзлийн аль нэг

хэлбэрийг гаргаагүй байхаар хангагдана¹⁶.

Мөн гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай нь нотлогдсон этгээд тухайн хэрэгтээ хоёр удаа эрүүгийн хариуцлага хүлээхгүй байх шаардлага нь шударга ёсны зарчмын агуулга болдог. Энэ нь төр, хүн бүр хууль, шүүхийн өмнө ямар ч ялгаваргүйгээр тэгш эрхтэй байх эрхээ баталгаатай эдлэх бүх нөхцөл бүрдүүлэх үүргийг иргэдийнхээ өмнө хүлээх¹⁷ ёстой гэсэн зарчмаар тайлбарлагдана. Шударга ёсны зарчим нь дараах байдлаар илэрхийлэгдэнэ. Үүнд:

- Эрүүгийн хуулиар сонгох болон харьцангуй тодорхой санкц, хариуцлагыг хөнгөрүүлэх, хүндрүүлэх нөхцөл байдлыг сонголт хийх хангалттай боломжтойгоор тогтоон, гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруутай этгээдийн хувийн байдал, хэргийн нөхцөл байдалд тулгуурлан ялын төрөл, хэмжээг зөвөөр оногдуулах нь шударга ёсны зарчимд нийцнэ.
- Үйлдсэн нэг гэмт хэргийн төлөө хоёр буюу түүнээс дээш удаа эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй байх нь шударга ёсны зарчмын зайлшгүй нэг хэсэг мөн. Энэ зарчим нь *ne bis in idem* буюу нэг гэмт хэрэгт хоёр удаа хариуцлага хүлээлгэхгүй байх эртний Римийн эрх зүйгээс үүсэлтэй. Нэг хэрэгт үндсэн ялын чанартай хэрэглэгддэг ялыг давхардуулан оногдуулах, эсвэл үйлдсэн гэмт хэргийн төлөө эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн мөртөө дахин уг хэргээр эрүүгийн хариуцлагад татаж болохгүй гэсэн агуулгаар илэрнэ. Энэхүү хэм хэмжээ нь Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 14 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг, түүнчлэн Хүний үндсэн эрх, эрх чөлөөг хамгаалах тухай Европын конвенцын 7 дугаар протоколд тус тус хуульчлагдсан эрх зүйн чухал зарчим юм. Олон улсын эдгээр холбогдох хэм хэмжээнд «хэн боловч нэг улсын эрүүгийн болон эрүүгийн процессын хуулиар үйлдсэн гэмт хэрэгтээ шийтгэгдсэн,

¹⁶ Г.Совд. Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар. УБ., 2002 он. 12-13 дахь тал

¹⁷ С.Жанцан. Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол. УБ., 2009 он. 34-36 дахь тал

эсхүл цагаатгагдсан бол хоёр дахь удаагаа тэр улсын хуулиар эрүүгийн журмаар хариуцлага хүлээхгүй» гэж заасан нь Үндсэн хуулийн 10 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасны дагуу үйлчлэх учир гадаад улсад үйлдсэн гэмт хэрэгтээ ял шийтгүүлж, түүнийгээ эдэлсэн Монгол Улсын иргэн эх орондоо буцаж ирсэн тохиолдолд гадаад улсад эдэлсэн ял нь хэт хөнгөн, эсхүл Монгол Улсын Эрүүгийн хуульд нийцэхгүй байна гэдэг үндэслэлээр дахин эрүүгийн хариуцлага хүлээлгэх ёсгүй гэсэн үг юм¹⁸.

- Шударга ёсны зарчмыг хангах эцсийн шат нь шүүхийн үндсэн үүрэгт хамаарах бөгөөд шүүх гагцхүү хуульд захирагдаж, хэнээс ч хараат бус бие даан, хэрэгт хувийн сонирхолгүй хандан, тохиолдлын хуваарилалтаар эрүүгийн хэргийг өөрийн бүрэн эрхийн хүрээнд шийдвэрлэж байх нь шударга ёсны зарчмыг хангах үндэслэл болно.¹⁹

Эртний Ромчууд Юстинианы хуульдаа *ne bis in idem* зарчмын агуулгыг анх тусгасан гэж үздэг хэдий ч МЭӨ 355 дугаар онд Афины улс төрч, дипломатч, уран илтгэгч Демосфен тус зарчмын агуулгыг «нэг этгээдэд нэг үйлдэлд нь хоёр удаа хариуцлага хүлээлгэхийг хууль хориглодог» хэмээн тодорхойлж байжээ.²⁰ Энэхүү нэр томъёог латин хэлнээс орчуулбал «Нэг ижил зүйлд хоёр дахин хариуцлага хүлээхгүй» гэсэн утгатай. Тухайлбал, Брокгауз болон Ефрон нарын толь бичигт «нэг ижил гэмт үйлдэл нь хоёр удаа эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зүйл болохгүй байх тухай эрх зүйн зарчим» хэмээн тодорхойлжээ²¹.

Энэ зарчим нь зөвхөн эрүүгийн болон эрүүгийн хэрэг хянан

¹⁸ Монгол Улсын Дээд шүүхийн Эрүүгийн эрх зүйн танхим, Ханнс-Зайделийн сан, Эрх зүйн боловсрол академи. Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар. УБ., 2013 он. 47 дахь тал

¹⁹ Ж.Авхиа, Б.Ганболд нар. Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар. УБ., 2002 он. 33-34 дэх тал

²⁰ <https://criminal.findlaw.com/criminal-rights/the-concept-of-double-jeopardy-background.html#:~:text=In%20355%20B.C.%20Athenian%20statesmen,teachings%20of%20early%20Christian%20writers>

²¹ Энциклопедический словарь Брокгауза и Ефрона, https://ru.wikisource.org/wiki/%D0%AD%D0%A1%D0%91%D0%95/Ne_bis_in_idem

шийдвэрлэх эрх зүйн хүрээнд бус илүү өргөн хүрээнд хэрэглэгдэж болохуйц юм. Тухайлбал, энэхүү зарчим нь захиргааны эрх зүй зэрэг бусад эрх зүйд мөн адил үйлчилж болохоор байна²². Энэхүү байр суурийг дэмжин эрдэмтэн, судлаач, хуульч И.Я.Фойницкий өөрийн бүтээлдээ *ne bis in idem* зарчим нь зөвхөн эрүүгийн гэмт хэрэгт хариуцлага хүлээлгэх хүрээнд биш бусад эрх зүйн хүрээнд тухайлбал, захиргааны хариуцлага ногдуулахад хэрэглэгдэх боломжтой»²³ хэмээн дурдаж байжээ. Улмаар орчин үед уг зарчмыг улс орнууд Үндсэн хууль болон бусад салбар хуульдаа тусган баталгаажуулах болсон юм.

Иргэний ба улс төрийн эрхийн пактын 14 дүгээр зүйлийн 7-д «Үйлдсэн гэмт хэрэгтээ тухайн улсын хууль болон эрүүгийн байцаан шийтгэх хуулийн дагуу эцэслэн шийтгүүлсэн буюу цагаатгагдсан хэнийг ч тэрхүү гэмт хэргээр нь дахин шүүх буюу шийтгэх ёсгүй» хэмээн заасан нь *ne bis in idem* зарчмын илэрхийлэл болж байна. *Ne bis in idem* зарчим нь олон улсын эрх зүй талаасаа олон ойлголтыг өөртөө агуулдаг ба тэдгээрийн нэг нь тухайн орны нутаг дэвсгэрт нэгэнт хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр гарсан тохиолдолд гэмт хэрэг үйлдсэн этгээдийг шилжүүлэн өгөхгүй байх ойлголт юм. Хэвтээ тэнхлэгт харилцаа буюу улс орнууд хоорондын байгуулсан ялтан шилжүүлэх тухай олон улсын баримт бичгээс *ne bis in idem* зарчмын уламжлалт томъёоллыг харах боломжтой. Тухайлбал, Ялтан шилжүүлэх тухай Европын Конвенцын 9 дүгээр зүйлд «хүсэлт гаргаж буй улсад тухайн гэмт хэрэг үйлдсэн этгээдтэй холбогдуулан хуулийн хүчин төгөлдөр шийдвэр гарсан, энэ нь шилжүүлэх хүсэлт гаргаж буй гэмт хэрэгтэй ижил бол шилжүүлэн өгөхгүй байх» тухай тусгагджээ.

Мөн Иргэний ба улс төрийн эрхийн тухай олон улсын пактад туссан *ne bis in idem* зарчмын талаар НҮБ-ын Хүний эрхийн хорооны 90 дүгээр хуралдаанаас гаргасан 32-р Ерөнхий зөвлөмжид

²² Матвеев Е.С., «Принцип Non bis in idem в уголовно-процессуальном кодексе Российской Федерации», судалгааны ажил.

²³ Фойницкий И.Я. Курс уголовного судопроизводства: учеб. пособие. Том 2. 1999, 607 с.

дараах байдлаар тусгайлан тайлбарлажээ²⁴.

...Энэхүү заалт нь нэг гэмт хэрэгт ял шийтгэгдсэн, эсвэл цагаатгагдсан этгээдийг тухайн гэмт хэргээр нь дахин тухайн шүүхэд дуудах, эсвэл өөр шүүх бүрэлдэхүүнээр хэргийг дахин хэлэлцүүлэхийг хориглосон байна. Тухайлбал, шүүхээр шийдэгдсэн этгээдийг тухайн гэмт хэрэгт холбогдуулан цэргийн шүүх, эсвэл тусгай шүүхэд дахин дуудах ёсгүй. Тус пактын 14 дүгээр зүйлийн 14.7 дахь хэсэг өөрийнх нь оролцоогүй шүүх хурлаар хэргийг шийдвэрлэсэн тохиолдолд өөрөө хүсвэл дахин шүүх хуралдаан явуулахыг хориглодоггүй бөгөөд тухайн шүүх хуралдаанаас гарсан шийдвэр буюу хоёр дахь шийтгэх тогтоолд хэрэглэгддэг байна.

Шашны болон итгэл үнэмшлийн шалтгаанаар цэргийн алба хаахаас татгалзсан этгээдийг ял шийтгэсэн бөгөөд дахин тэрхүү үндэслэлээр татгалзсан хэмээн шийтгэх нь нэг гэмт хэрэгт дахин ял шийтгэж буй явдал болно.

Хэрэв давж заалдах шатны шүүх нь анхан шатны шийтгэх тогтоолыг хүчингүй болгон хэргийг анхан шатны шүүхэд буцаасан тохиолдолд тус пактын 14 дүгээр зүйлийн 14.7-г зөрчсөн хэмээн үзэхгүй. Түүнчлэн, энэхүү зүйл нь тусгай нөхцөл байдал тухайлбал, цагаатгах шийдвэр гаргах үед ил болоогүй, эсвэл мэдэгдэх боломжгүй байсан нотлох баримт ил болсон зэрэг нөхцөл байдлын үед хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг сэргээхийг хориглодоггүй байна.

Энэхүү баталгаа нь зөвхөн эрүүгийн гэмт хэрэгт хамаарах ба пактын 14 дүгээр зүйлийн агуулгын дагуу эрүүгийн гэмт хэрэгт оноож буй санкц хэмээн тооцогдохгүй сахилгын арга хэмжээнд хамаарахгүй. Цаашилбал, хоёр эсвэл түүнээс дээш улсын шүүн таслах шатанд *ne bis in idem* зарчим баталгаа болохгүй. Гэхдээ энэхүү ойлголт нь олон улсын конвенцоор дамжуулан нэг гэмт хэрэгт холбогдуулан шүүхийн дахин хянан шийдвэрлэх ажиллагаанаас сэргийлэх гэж буй улс орнуудын хүчин чармайлтыг үгүйсгэх ёсгүй.

²⁴ Human rights committee, Ninetieth session Geneva, 9 to 27 July 2007, General Comment No. 32,

ХОЁР. ЭРҮҮГИЙН ХУУЛИЙН ТУСГАЙ АНГИЙН 12.1 ДҮГЭЭР ЗҮЙЛИЙН 2.7 БОЛОН 12.3 ДУГААР ЗҮЙЛИЙН 2.3 ДАХЬ ХЭСЭГТ ЗААСАН ГЭМТ ХЭРГИЙН ХЭРЭГЖИЛТ, ҮР НӨЛӨӨ

Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт «Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн» гэж, 10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт «Монгол Улс олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримталж энхийг эрхэмлэсэн гадаад бодлого явуулна», 3 дахь хэсэгт «Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ» гэж шударга ёсны зарчмын үндсэн эх сурвалжийг зохицуулсан. Манай улс олон улсын гэрээг соёрхон баталж, нэгдэн орсныхоо хувьд олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг өөрийн орны эрх зүйд нэвтрүүлэн, сахин биелүүлэх үүрэгтэй. Үүний нэг илрэл нь Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт болон Олон улсын Эрүүгийн шүүхийн Ромын дүрэмд тусгагдсан *ne bis in idem*²⁵ буюу нэг гэмт хэрэгт нэг л удаа ял шийтгүүлэх шударга ёсны зарчмын асуудал юм.

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт нь Хүний эрхийн түгээмэл тунхаглалд заасан хүн бүр өөрийн улс төр, иргэний эрхээ эдийн засаг, нийгэм, соёлын эрхээ эдлэхтэй адил тэгш, салшгүй эдлэх бөгөөд эдгээр эрх нь хүнд угаас заяасан нэр төрөөс үүдэн гарч байгааг хүлээн зөвшөөрөх, НҮБ-ын дүрэмд тунхаглан заасан хүн төрөлхтөнд угаас заяасан нэр төр болон тэдний адил тэгш, салшгүй эрхийг хүлээн зөвшөөрөх нь эрх чөлөө, шударга ёс, бүх нийтийн энх тайвны үндэс мөн болохыг хүлээн зөвшөөрөх, хүндэтгэн сахих үүднээс улс орнуудын тохиролцсон хамтран ажиллах олон улсын гэрээ юм. Иргэний болон улс төрийн

²⁵ Англи хэлэнд «Non double jeopardy» гэж нэрлэдэг.

эрхийн тухай олон улсын пактын 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт «Шүүх ба тусгай шүүхийн өмнө бүх хүн тэгш эрхтэй. Хүн бүр өөрт тулгасан эрүүгийн хэргийг хянан хэлэлцүүлэх буюу иргэний нэхэмжлэлийн хүрээнд эрх, үүргээ тодорхойлуулахдаа хуулийн дагуу байгуулагдсан эрх бүхий, хараат бус, тал үл харах шүүхээр нээлттэй, шударгаар шүүлгэх эрхтэй» гэж, 7 дахь хэсэгт «Үйлдсэн гэмт хэрэгтээ тухайн улсын хууль болон эрүүгийн байцаан шийтгэх хуулийн дагуу эцэслэн шийтгүүлсэн буюу цагаатгагдсан хэнийг ч тэрхүү гэмт хэргээр дахин шүүх буюу шийтгэх ёсгүй» гэж тус тус заасан²⁶.

Харин Олон улсын Эрүүгийн шүүхийн Ромын дүрэм нь сая сая хүүхэд, эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд хүн төрөлхтний сэтгэл зүрхийг шимшрүүлсэн санаанд багтамгүй хорон үйлдлийн золиос болсныг эргэн санах, тэдгээр хүнд ноцтой гэмт хэрэг нь дэлхий нийтийн энх тайван, аюулгүй байдал болон сайн сайханд аюул заналхийлэл учруулж байгааг хүлээн зөвшөөрөх, ял шийтгэл оногдуулах арга хэмжээг үндэсний түвшинд хэрэгжүүлэх, олон улсын хамтын ажиллагааг идэвхжүүлэх замаар хангах ёстой болохыг батлан илэрхийлэх, урьдчилан сэргийлэх, өнөөгийн болон хойч үеийн тусын тулд НҮБ-ын тогтолцоотой холбоо бүхий олон улсын хамтын нийгэмлэгийн сэтгэлийг түгшээсэн хамгийн ноцтой гэмт хэргийг шүүн шийдвэрлэх эрх бүхий бие даасан, байнгын үйл ажиллагаатай олон улсын эрүүгийн шүүх байгуулах, энэ нь үндэсний байгууллагад нэмэлт хөшүүрэг болохыг онцлон тэмдэглэх, олон улсын шүүн таслах ажиллагааг хэрэгжүүлэхэд хүндэтгэлтэй хандах, түүнийг сахин биелүүлэх явдлыг хангах зорилго бүхий олон улсын гэрээ юм.

²⁶ <https://www.legalinfo.mn/law/details/1257>

Олон улсын эрүүгийн шүүхийн Ромын дүрэм, 20 дугаар зүйл

1. Энэхүү дүрэмд зааснаас бусад тохиолдолд шүүхээс тухайн хүнийг гэм буруутай болохыг хүлээн зөвшөөрөх буюу цагаатгахаас өмнө гэмт хэргийн бүрэлдэхүүний үндэс болсон үйлдлийн төлөө ямар ч хүнийг шийтгэж болохгүй.
2. Ямар ч хүнийг 5 дугаар зүйлд дурдсан гэмт хэрэг үйлдсэнтэй холбогдуулж шүүхээс нэгэнт гэм буруутайг нь нотолсон буюу цагаатгасан бол түүнд өөр шүүхээс ял ногдуулж болохгүй.
3. Хэрэв өөр шүүхээс явуулсан шүүх ажиллагаа нь дараах тохиолдолд бус бол, түүнчлэн 6, 7 болон 8 дугаар зүйлд заасан үйлдлийн төлөө өөр шүүхээр шийтгэгдсэн ямар ч хүнийг тухайн үйлдлийн төлөө шүүхээс шийтгэл ногдуулж болохгүй:
 - a. Шүүхийн шүүн шийдвэрлэх харьяалалд хамрагдах гэмт хэргийн төлөө тухайн хүнийг эрүүгийн хариуцлага хүлээхээс хаацайлахад зориулагдсан;
 - b. өөр шалтгаанаар олон улсын эрх зүйгээр хүлээн зөвшөөрөгдсөн хуулийн зүй ёсны журам, хэм хэмжээний дагуу хараат бус буюу шударга байдлаар явагдаагүй бөгөөд тийнхүү байгаа нөхцөл байдалд тухайн хүнийг шүүн таслах ажиллагаанд шилжүүлэх зорилго хангагдаагүй байдлаар явагдсан.

Тус дүрмийн 20 дугаар зүйлд заасан *ne bis in idem* зарчим бол гэмт хэрэг үйлдсэн хүнийг тухайн үйлдлийн төлөө дахин шүүх буюу шийтгэх ёсгүй болохыг илтгэнэ. Гэхдээ гэмт хэрэг үйлдсэн хүнийг эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх болон шүүн таслах ажиллагааны зорилго хангагдаагүй тохиолдол үүнд хамаарахгүй гэж зохицуулжээ.

Улсын Их Хурлын 1998 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн 18 дугаар тогтоолоор²⁷ Монгол Улсын Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр, үндсэн чиглэл, төлөвлөгөөг баталсан²⁸. Тус тогтоолын 1 дүгээр хавсралтаар хүний эрх, эрх чөлөө, түүний хууль зүйн баталгааг хангах чиглэлийг мөн баталсан билээ. Энэ хүрээнд хүний үндсэн эрх, эрх чөлөөг үндэсний хууль тогтоомжоор бататгахдаа Монгол Улсын олон улсын гэрээний агуулгад нийцүүлэн,

²⁷ Хавсралт 1 – Монгол Улсын Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр, Хавсралт 2 – Монгол Улсын хууль тогтоомжийг 2000 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл, Хавсралт 3 – Монгол Улсын Эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө

²⁸ <https://www.legalinfo.mn/law/details/6881>

тэдгээрээр хүлээсэн үүргээ биелүүлэх, хүний эрхийн үзэл санааг түгээн дэлгэрүүлэх, хүний эрхийн тухай хууль тогтоомжийг тайлбарлан таниулах, энэ талаарх олон улсын гэрээ, үндэсний хууль тогтоомжийн хэрэгжилтийг тогтмол судлах арга хэмжээ авч, хүний эрхтэй холбоотой хууль тогтоомжийг боловсронгуй болгох асуудлыг тусгажээ. Мөн тус тогтоолын 2 дугаар хавсралтад хүний эрх, эрх чөлөө, түүний хууль зүйн баталгааг хангах хүрээнд Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх хуулийг шинэчлэн найруулахаар шийдвэрлэжээ.

Улмаар 2002 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр шинэчилсэн Эрүүгийн хуулийг баталсан. Тус хуулийг 1992 оны Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцүүлэн боловсруулж мөрдсөнөөс хойш цаг үеийн нөхцөл, байдал, нийгмийн захиалга, шаардлагаар олон удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. Дээрх нэмэлт, өөрчлөлтүүд нь хохирлын хэмжээ болон гэмт хэрэгт тооцох нөхцөлийг тодорхой болгох, шинэ гэмт хэргийн бүрэлдэхүүнийг хуульчлах, Монгол Улсын олон улсын гэрээ, конвенцод шинээр орсон, соёрхон баталсан, түүнчлэн өөр бусад хууль шинээр батлагдаж, зарим хуульд өөрчлөлт орсонтой холбоотойгоор хийгджээ. Гэвч өнөөгийн нийгмийн харилцааны хөгжил, эрэлт хэрэгцээтэй холбон авч үзвэл Үндсэн хуулиар тунхагласан үнэт зүйлсийг бүрэн дүүрэн хамгаалж чадаагүй, даяаршиж буй эрин үед олон улсын нийтийн эрх зүйн хөгжлөөс хоцрох хандлагатай байсан.

Гэмт хэргийн тухай хуулийн төслийн танилцуулгад дурдсанаар шударга ёсыг хамгаалах тогтолцооны үндсийг бүрдүүлэх үүднээс хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийн байгууллага, судалгаа, эрдэм шинжилгээний байгууллага, эрдэмтэн, судлаачдаас Эрүүгийн хуулийн эерэг болон сөрөг үр нөлөө, хэрэгжилтийн талаар хийсэн 20 гаруй судалгаа, хуулийн төсөлд дурдсан Эрүүгийн хуулийн үзэл баримтлал, зарчим, ерөнхий анги, тусгай ангийг бүхэлд нь шинэчлэх талаарх байр суурь, санал шүүмжлэл, зөвлөмжийг харгалзан үзэж, ардчилсан нийгмийн харилцаанд тохирсон, Монгол Улсын Үндсэн хуулиар хамгаалагдсан хүний суурь эрх, халдашгүй

байдлыг илүү баталгаажуулсан, олон улсын нийтийн эрх зүйн хөгжлийн чиг хандлагад нийцсэн урт хугацаанд тогтвортой үйлчлэх хуулийг батлан гаргах зүй ёсны шаардлага урган гарчээ.

Улсын Их Хурлын 2012 оны 09 дүгээр сарын 18-ны өдрийн 37 дугаар тогтоолоор Монгол Улсын Засгийн газрын 2012–2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг баталсан билээ. Тус хөтөлбөрийн 5 дугаар зүйл (Эрх чөлөөтэй Монгол хүн)-д Ардчилсан нийгмийн үнэт зүйл, зарчим, улс орны хөгжлийн шаардлагад нийцсэн, авлига, албан тушаалын болон шинэ төрлийн гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хариуцлага тооцох чадавхтай эрүүгийн хууль тогтоомжийн тогтолцоог бүрдүүлж, ялын бодлогыг оновчтой, үр нөлөөтэй, олон сонголттой болгох зорилт, шинэчлэлийг хэрэгжүүлэхээр тусгасан. Энэхүү шинэчлэлийн хүрээнд Гэмт хэргийн тухай хуулийн²⁹ төсөл боловсруулж эхэлсэн бөгөөд тус хуулийн төслийн ерөнхий ангид дараах өөрчлөлт хийхээр тусгагджээ. Үүнд:

- Хууль ёсны зарчим, гэм буруутай нь тогтоогдсон тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээх, хүн бүр хууль, шүүхийн өмнө эрх тэгш байх, шударга ёсны болон энэрэнгүй ёсны зарчмууд, гэмт хэрэг үйлдсэн гэм буруутай этгээд зөвхөн өөрөө хариуцлага хүлээх, эрүүгийн хариуцлага гарцаагүй байх зэрэг 7 зарчмын агуулгыг өөрчилж боловсруулснаар шүүх хуульд заасан зарчмыг баримталж хэрэг шийдвэрлэх боломж бүрдэнэ.
- Онц аюултай гэмт хэрэгтэн, ялтай байдал, урьд ял шийтгүүлсэн, гэмт хэрэг давтан үйлдсэн гэж хүндрүүлэн үзэхээр нэрлэн заасан, хууль зүйн үр дагавар үүсгэдэг ойлголтыг өөрчилж, тусгай ангийн хүндрүүлэх бүрэлдэхүүн болгон авч үзэхгүй байхаар хуулийн төсөлд тусгана. Эрүүгийн хуулийн нийт 49 зүйлд гэмт хэргийг давтан үйлдсэн, 13 зүйлд урьд ял шийтгүүлсэн бол хүндрүүлж үзэхээр заажээ. Энэ

²⁹ 2015 онд батлагдсан Эрүүгийн хуулийн төслийг хууль санаачлагч «Гэмт хэргийн тухай хуулийн төсөл» гэж нэрлэж байсан.

нь нэг гэмт хэрэгт нэг удаа ял шийтгэх буюу олон улсын нийтээр хүлээн зөвшөөрсөн *Non double jeopardy* зарчмыг гажуудуулахад хүргэж, аливаа гэмт хэрэгт ял шийтгүүлж, эдэлсний дараа түүний үр дагаврыг хүндрүүлэн хэрэглэж байгааг өөрчлөн хуулийн төслийн Ерөнхий ангид ял хүндрүүлэх нөхцөл байдал гэсэн хэсэгт тусгана³⁰ гэжээ.

Дээрх хуулийн төсөл агуулгын хувьд Улсын Их Хурлын чуулганаар хэлэлцэгдэж, 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр шинэчилсэн Эрүүгийн хууль батлагдсан бөгөөд 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөж эхэлсэн. Тус хуулийн 1.3 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт нэг гэмт хэрэгт нэг удаа ял оногдуулна гэж шударга ёсны зарчмын үндсэн шинжийг заасан байна.

Ийнхүү ямар ч хүнийг үйлдсэн гэмт хэрэгт нь шүүхээс хуулийн дагуу эцэслэн шийтгэсэн буюу цагаатгасан тохиолдолд тэрхүү гэмт хэргээр нь дахин шүүх буюу шийтгэхийг хориглодог *Double jeopardy (ne bis in idem)* гэсэн Эрүүгийн эрх зүйн онолын зарчмыг НҮБ-аас баталсан Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 14 дүгээр зүйлийн 7 дахь хэсэг, Ромын дүрмийн 20 дугаар зүйлийн 2 дахь хэсгээр тус тус тогтоож, нийтээр хүлээн зөвшөөрч хэм хэмжээ тогтоосон бөгөөд Монгол Улс уг зарчмыг Эрүүгийн хуулийн ерөнхий ангидаа тухайлан хуульчилж, тусгажээ³¹.

Гэтэл тус хуулийн 12 дугаар бүлгийн³² 12.1 дүгээр зүйл (Хүчиндэх)-ийн 2.7 дахь заалт болон 12.3 дугаар зүйл (Бэлгийн мөлжлөг)-ийн 2.2 дахь заалтад «урьд нь энэ бүлэгт заасан гэмт хэрэг үйлдэж гэм буруутайд тооцогдож байсан хүн» хэмээн хүндрүүлэх бүрэлдэхүүн болгон хуульчилсан. Энэ нь хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдэж, тэрхүү үйлдэлдээ ял шийтгэгдсэн хүн дахин энэ төрлийн гэмт хэрэг үйлдвэл эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэн хэрэглэх нөхцөл байдлыг үүсгэсэн юм.

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар шинэчилсэн Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.1 дүгээр зүйлийн 2.7 дахь

³⁰ <https://mojha.gov.mn/newmojha/?p=557>

³¹ <http://www.supremecourt.mn/eruu/view?id=2270>

³² Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг

заалтаар анхан шатны шүүхээр хянан шийдвэрлэгдсэн гэмт хэргийн талаарх мэдээллийг³³ хүснэгтээр харуулъя. Үүнд:

Хүснэгт 1

| Урьд нь энэ бүлэгт заасан гэмт хэрэг үйлдэж гэм буруутайд тооцогдож байсан хүн | | 2017 он | 2018 он | 2019 он | Нийт |
|--------------------------------------------------------------------------------|------------------|---------|---------|---------|------|
| Шийдвэрлэгдсэн хэрэг | | 2 | 7 | 2 | 11 |
| Хэрэг шийдвэрлэсэн шүүх | Хөдөө орон нутаг | 2 | 4 | - | |
| | Нийслэл | - | 3 | 2 | |
| Ял шийтгүүлсэн хүн | | 2 | 7 | 2 | 11 |
| Хүйс | Эрэгтэй | 2 | 7 | 2 | |
| | Эмэгтэй | - | - | - | |
| Давтамж | 2 удаа | 2 | 2 | 1 | |
| | 3, түүнээс дээш | - | 5 | 1 | |
| | 18-21 | - | 1 | - | |
| | 22-29 | 1 | 3 | - | |
| Нас | 30-34 | 1 | 1 | 1 | |
| | 35-аас дээш | - | 2 | 1 | |
| Хөдөлмөр эрхлэлтийн байдал | Малчин | - | 1 | - | |
| | Ажилгүй | 2 | 5 | 1 | |
| | Бусад | - | 1 | - | |

Дээр хүснэгтээс үзвэл, өнгөрсөн 3 жилийн хугацаанд хүчиндэх гэмт хэрэг дахин үйлдэж анхан шатны шүүхээр ял шийтгүүлсэн нийт 11 хүн байна. Уг ялаар шийтгүүлсэн хүмүүст 1-8 хүртэлх жилийн хорих ял оногдуулжээ³⁴. Учир нь тус зүйлчлэлийн эрүүгийн хариуцлага нь зөвхөн хорих ял юм³⁵. Өөрөөр хэлбэл, дээрх 11 хүнд *ne bis in idem* буюу «нэг гэмт хэрэгт нэг л удаа ял шийтгүүлэх» олон улсын гэрээ, конвенц болон Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүгийн хуульд заасан шударга ёсны зарчим алдагдсан гэж үзэхээр байна. Харин Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.3 дугаар зүйлийн 2.2

³³ Шүүхийн ерөнхий зөвлөлийн ажлын албаны 2020 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 04/682 дугаар «Хариу хүргүүлэх тухай» албан бичиг

³⁴ <http://new.shuukh.mn/eruanhan>

³⁵ 2-8 хүртэл жилийн хорих ялын хугацааг 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн Эрүүгийн хуулийн өөрчлөлтөөр 5-12 жил хүртэл болгон ихэсгэсэн.

дахь заалт буюу Бэлгийн мөлжлөг гэмт хэргээр ял шийтгүүлсэн хүн хараахан байхгүй байна. Үүнийг жишээ болгон шударга ёсны зарчим хэрэгжиж чадахгүй байгаа тодорхой нэг тохиолдлыг шинжилье.

Шийтгээ 1.

Шүүгдэгч Т.О нь «Баянзүрх дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2010 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 65 дугаар шийтгэх тогтоолоор Эрүүгийн хуулийн тусгай ангийн 126 дугаар зүйлийн 126.2.3 дахь хэсэгт зааснаар 5 жил 1 сарын хорих ялаар шийтгүүлснийг Нийслэлийн эрүүгийн хэргийн давж заалдах шатны шүүхийн 2010 оны 04 дүгээр сарын 01-ний өдрийн 248 дугаар магадлалаар 3 жил 5 сарын хорих ял болгон өөрчилж байсан. Мөн Дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны 2 дугаар шүүхийн 2014 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 341 дугаартай шийтгэх тогтоолоор Эрүүгийн хуулийн 98 дугаар зүйлийн 98.1, 126 дугаар зүйлийн 126.2.3 дахь хэсэгт зааснаар 5 жил 6 сарын хорих ялаар тус тус шийтгүүлсэн» бөгөөд 2017 оны 03 дугаар сарын 03-ны өдрийн Баянзүрх дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн захирамжаар эдлээгүй үлдсэн 1 жил 2 сар 6 хоногийн хорих ялыг хугацаанаас нь өмнө тэнсэн суллажээ.

Гэтэл тэрээр 2017 оны 07 дугаар сараас 08 дугаар сарын хооронд дахин хүчиндэх гэмт хэрэг үйлдсэн байна. Тус үйлдэлд нь Баянзүрх дүүргийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн 2018 оны 07 дугаар сарын 17-ны өдрийн 1015 дугаар шийтгэх тогтоолоор Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.1 дүгээр зүйлийн 2.7 дахь хэсэгт зааснаар урьд нь хүчиндэх гэмт хэрэг үйлдэж ял шийтгэгдэж байсан гэсэн үндэслэлээр гэмт хэргийн зүйлчлэлийг хүндрүүлэн 3 жил 2 сарын хорих ял оногдуулж, тус хорих ял дээр өмнөх шийтгэх тогтоолоор оногдуулсан хорих ялаас эдлээгүй үлдсэн 1 жил 2 сар 6 хоногийн хорих ялыг нэмж нэгтгэн нийт 4 жил 4 сар 6 хоногийн хугацаагаар хорих ялаар шийтгэжээ.

Дээрх шүүхийн шийдвэрээс үзэхэд, өмнө нь 2 удаа хүчиндэх гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн байгаа нь сүүлд үйлдсэн гэмт хэргийн зүйлчлэлд шууд нөлөөлж, 2 жилээр илүү хорих ял шийтгүүлэх үр дагавар үүсгэж байгааг харуулж байна. Өөрөөр хэлбэл, шүүгдэгч Т.О нь хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдэж байгаа хэдий ч өмнө нь үйлдэж ял шийтгэгдсэн гэмт хэргийнхээ үр дагаврыг дахин хариуцах нь шударга ёсонд үл нийцэх билээ.

Судалгааны багийн судлаачийн зүгээс 2018 оны 09 дүгээр сарын 21-ний өдөр Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.1 дүгээр зүйлийн 2.7 болон 12.3 дугаар зүйлийн 2.2 дахь заалтыг Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх асуудлаар дүгнэлт гаргуулахаар Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд мэдээлэл гаргасан билээ. Гэтэл Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүний 2018 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 161 дүгээр тогтоолоор Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэхээс татгалзсан. Тус тогтоолд:

1. Эрүүгийн хуулийн ерөнхий ангид эрүүгийн хариуцлага хүлээлгэхэд гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, гэмт хэрэг үйлдсэн хүний хувийн байдал, эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх, хүндрүүлэх нөхцөл байдлыг тал бүрээс нь харгалзан үзэхээр заасан ба тус хуулийн 6.6 дугаар зүйлд энэ хуулийн тусгай ангийн нэг бүлэгт заасан санаатай гэмт хэргийг хоёр, түүнээс дээш удаа үйлдсэн, эсхүл гэмт хэргийг бүлэглэж үйлдсэн бол эрүүгийн хариуцлагыг хүндрүүлэх нөхцөл байдалд авч үзэхээр хуульчилсан байна.
2. Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлд зааснаар хууль тогтоогч буюу Улсын Их Хурал эрүүгийн ялын бодлогыг тодорхойлон Эрүүгийн хуулийг батлах замаар ямар үйлдлийг гэмт хэрэгт тооцохыг тогтоох, мөн Үндсэн хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан иргэний эрхийг хамгаалан, хууль зүйн баталгааг хангах зорилгоор холбогдох зохицуулалтыг тусган гэмт хэргийн шинж чанараас хамааран хөнгөрүүлэх болон хүндрүүлэх нөхцөлийг тогтоох бүрэн эрхтэй. Энэ хүрээнд Эрүүгийн хуулийн 12 дугаар бүлэг Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг «Хүчиндэх, бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах, бэлгийн мөлжлөг, арван зургаан насанд хүрээгүй хүнтэй бэлгийн харилцаанд орох» зэрэг гэмт хэрэг үйлдэж гэм буруутайд тооцогдож байсан бол хүндрүүлэх бүрэлдэхүүн

болгон хуульчилсан нь Үндсэн хуулийн маргааны шинжийг агуулахгүй байна.

3. Түүнчлэн мэдээлэл гаргагч нь мэдээлэлдээ Эрүүгийн хуулийн 12.1 дүгээр зүйлийн 2.7 дахь заалт, мөн хуулийн 12.3 дугаар зүйлийн 2.2 дахь заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 16 дугаар зүйлийн 14 дэх заалт, 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийг тус тус зөрчсөн гэж үзсэн боловч Үндсэн хуулийн заалтыг зөрчсөн талаар утга зүйн хамаарлыг бүрэн тусгаагүй, мэдээлэлд дурдсан гол үндэслэл, шаардлага нь агуулгын хувьд тодорхой бус байна. Тухайлбал, Үндсэн хуульд заасан шударга шүүх гэдэг ойлголт нь хуулийн дагуу байгуулагдсан бүхий л шатны шүүхийг ойлгох юм. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт Үндсэн хуулиас бусад хуулийг зөрчсөн эсэх тухай маргааныг Цэц харьяалан шийдвэрлэхгүй гэж заасан байна. Харин мэдээллийн агуулгын хүрээнд хууль тогтоомжийг боловсронгуй болгох асуудал байгааг үгүйсгэхгүй.

Дээрхээс үзэхэд Үндсэн хуулийн цэцийн гишүүн мэдээлэлд дурдсан асуудал нь Улсын Их Хурлын хууль тогтоох бүрэн эрхэд хамаарах зүйл байх бөгөөд мэдээллийн агуулгын хүрээнд хууль тогтоомжийг боловсронгуй болгох асуудал байгааг үгүйсгэхгүй юм гэж дүгнэсэн. Өөрөөр хэлбэл, мэдээллийн агуулгыг шударга ёсны зарчмын өнцгөөс харж, *ne bis in idem* гэх ойлголтыг бүрэн тодорхойлж чадахгүй байна хэмээн судлаач дүгнэж байна.

Үүний нэг илрэл нь МХХ-ны Эрүүгийн эрх зүйн хорооны гишүүдээс авсан асуулгын үр дүнгээс мөн харагдаж байна. Тус хороонд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцож байгаа шүүгч, прокурор, мөрдөгч, өмгөөлөгч болон эрүүгийн эрх зүйн чиглэлээр дагнан судалдаг багш, судлаач нар харьяалагддаг бөгөөд нийт 80 хуульч асуулгад дараах байдлаар оролцсон байна.

Хүснэгт 2

| д/д | Ажил, мэргэжил | Ажилласан жил |
|-----------------------|----------------------|-------------------------|
| 1 | Шүүгч 4 (5%) | 3 хүртэл жил 22 (27,5%) |
| 2 | Прокурор 8 (10%) | 3-6 жил 16 (20%) |
| 3 | Өмгөөлөгч 50 (62,5%) | 6-9 жил 14 (17,5%) |
| 4 | Бусад 18 (22,5%) | 10 дээш жил 28 (35%) |
| НИЙТ 80 (100%) | | 80 (100%) |

Асуулгыг ажил, мэргэжлийн хувьд ихэвчлэн өмгөөлөгч нар идэвхтэй бөглөсөн байх бөгөөд мэргэжлээрээ 6 болон түүнээс жил ажилласан хуульчид оролцжээ.

Харин Олон улсын Эрүүгийн шүүхийн Ромын дүрэмд заасан *ne bis in idem* зарчим буюу «нэг гэмт хэрэгт нэг удаа ял шийтгүүлэх» шударга ёсны зарчмын талаар маш сайн гэж оролцогчдын 16 нь буюу 20 хувь, сайн гэж 38 буюу 47.5 хувь, дунд гэж 22 буюу 27.5 хувь, мэдэхгүй гэж 4 буюу 5 нь хувь тус тус хариулжээ. Мөн Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгаар 2002 оны Эрүүгийн хуулийн хүндрүүлэх бүрэлдэхүүнээс «гэмт хэрэг давтан үйлдэх» ойлголтыг хассан үндэслэл, шаардлагыг хэрхэн тайлбарлах вэ? гэсэн асуултад:

1. Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх, *ne bis in idem* зарчмыг дотоодын хууль тогтоомждоо тусгахтай холбоотой гэж оролцогчдын 38 буюу 47.5 хувь;
2. Эрүүгийн хариуцлагын зорилгод нийцэхгүй байсан буюу практик шаардлагаас илүү хамааралтай гэж 14 буюу 17.5 хувь;
3. Эрүүгийн хуулийн тусгай ангиас «гэмт хэрэг давтан үйлдэх» хүндрүүлэх бүрэлдэхүүнийг хассан нь зарчмын хувьд буруу байсан гэж 22 буюу 27.5 хувь;
4. Мэдэхгүй гэж 6 буюу 7.5 хувь тус тус хариулсан байна.

Дээрх санал асуулгын дүнгээс харахад, хуульчид Монгол Улс нь Олон улсын Эрүүгийн шүүхийн Ромын дүрэмд нэгдэн орсон тул олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж, *ne bis in idem* гэх шударга ёсны зарчмыг Эрүүгийн хуульдаа тусгасан болохыг сайн мэдэж байна гэж үзэхээр байна. Гэхдээ 2015 оны шинэчилсэн Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.1 дүгээр зүйлийн 2.7 болон 12.3 дугаар зүйлийн 2.2-д заасан «урьд нь энэ бүлэгт заасан гэмт хэргийг үйлдэж гэм буруутайд тооцогдож байсан хүн үйлдсэн» бол хүндрүүлэн зүйлчлэхээр зохицуулсан нь нэг гэмт хэрэгт нэг удаа ял оногдуулна гэсэн шударга ёсны зарчимд нийцэх эсэх талаар хуульчид санал нэгтгэйгээр хариулж чадаагүй байгаа нь доорх үр дүнгээс харагдаж байна.

График 1. ЭХТА-ийн 12.1 дүгээр зүйл (хүчиндэх)-ийн 2.7-д заасан "урьд нь энэ бүлэгт заасан гэмт хэргийг үйлдэж гэм буруутайд тооцогдож байсан хүн" гэсэн зохицуулалт "нэг гэмт хэрэг нэг удаа ял оногдуулна" гэсэн шударга ёсны зарчимд нийцэж байгаа эсэх





График 2. ЭХТА-ийн 12.3 дүгээр зүйл (хүчиндэх)-ийн 2.2-д заасан «урьд энэ бүлэгт заасан гэмт хэрэг үйлдэж гэм буруутайд тооцогдож байсан хүн» гэсэн зохицуулалт «нэг гэмт хэрэг нэг удаа ял оногдуулна» гэсэн шударга ёсны зарчимд нийцэж байгаа эсэх



Өөрөөр хэлбэл, тодорхой төрлийн гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүнд оруулсан зохицуулалтыг шударга ёсны зарчимд нийцэж байгаа эсэхэд хариулт өгч чадахгүй байгаа нь *ne bis in idem* зарчмын агуулгыг бүрэн мэдэхгүй байна гэж үзэж болохоор байгаа юм. Мөн дээрх зарчмын талаар өмнө нь өөрийн байр суурийг илэрхийлж байгаагүй гэж нийт судалгаанд оролцсон хуульчдын 80 хувь нь хариулжээ.

ГУРАВ. ГАДААД УЛС ОРНЫ ШУДАРГА ЁСНЫ ЗАРЧИМ (*NE BIS IN IDEM*)-ЫН ХЭРЭГЖИЛТ, ОНЦЛОГ, ТУРШЛАГА

Эрүүгийн эрх зүй дэх шударга ёсны зарчим буюу *ne bis in idem* нь утгачилбал, оногдуулж буй ял нь үйлдсэн гэмт хэрэгтээ тохирсон байна, нэг гэмт хэрэгт нэг л удаа эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ гэсэн санааг агуулдаг бөгөөд Англо-Саксоны эрх зүйн бүлийн орнуудад *Double jeopardy clause* гэсэн нэр томъёогоор илэрхийлэгддэг³⁶. Энэхүү зарчим нь хууль зүйн шинжлэх ухаан өндөр хөгжсөн орнуудын Үндсэн хуульд тусгагдсан байдаг бөгөөд тухайлбал, АНУ-ын Үндсэн хуулийн 5 дугаар нэмэлтэд «...үйлдсэн эрх зүйн нэг зөрчлийн төлөө хэний ч амь насыг хохироох, бие махбодыг зовоох, ял ногдуулахаар заналхийлж, хоёр удаа шийтгэж болохгүй...»³⁷ хэмээн баталгаажуулсан бол Азийн орнуудаас Япон Улсын Үндсэн хуулийн 39 дүгээр зүйлд «...хэнийг ч нэг гэмт хэрэгт хоёр удаа ял шийтгэж болохгүй»³⁸ хэмээн мөн тусгагдсан байдаг³⁹.

Оросын Холбооны Улс

Оросын Холбооны Улс (ОХУ)-ын Үндсэн хуулийн 50 дугаар зүйлийн 1-д «Хэн ч нэг гэмт хэрэгт хоёр удаа ял шийтгүүлэх ёсгүй»⁴⁰ гэж *ne bis in idem* зарчмын агуулгыг тунхагласан. Түүнчлэн

³⁶ Энхцэцэг С. Эрүүгийн эрх зүй дэх давтан гэмт хэргийг авч үзэх нь. УБ., 2007. 2 дахь тал.

³⁷ <http://www.law.emory.edu/index.php?id=3080>

³⁸ <http://www.solon.org/Constitutions/Japan/English/english-Constitution.html>

³⁹ <https://mergenii.wordpress.com/2011/01/09/ne-bis-in-idem-%D0%B7%D0%B0%D1%80%D1%87%D0%BC%D1%8B%D0%B3-%D0%B1%D0%B0%D1%82%D0%B0%D0%BB%D0%B3%D0%B0%D0%B0%D0%B6%D1%83%D1%83%D0%BB%D0%B0%D1%85-%D0%BD%D1%8C/>

⁴⁰ Бүх нийтийн санал асуулгаар 1993 оны 12 дугаар сарын 12-ны өдөр баталсан. Түүнээс хойш 2008 оны 12 дугаар сарын 30-ны өдөр N 6-ФКЗ, 2008 оны 12 дугаар сарын 30-ны өдөр N 7-ФКЗ, 2014 оны 2 дугаар сарын 05-ны өдөр N 2-ФКЗ, 2014 оны 7 дугаар сарын 21-ний өдөр N 11-ФКЗ зэрэг хуулиудаар нэмэлт, өөрчлөлт орсон.

уг зарчмыг тус улсын Эрүүгийн хууль⁴¹-ийн 6 дугаар зүйлд дараах байдлаар томъёолжээ. Үүнд:

1. Гэмт хэрэг үйлдсэн этгээдэд оногдуулж буй ял болон бусад эрүүгийн эрх зүйн шинжтэй арга хэмжээ нь шударга байх ёстой бөгөөд гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар болон хэмжээ, гэмт хэрэг үйлдсэн нөхцөл байдал болон үйлдсэн этгээдийн хувийн шинж байдалд тохирсон байх ёстой.
2. Хэн ч нэг гэмт хэрэгт эрүүгийн хариуцлагыг хоёр удаа хүлээхгүй.

Мөн тус улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль⁴²-ийн 27 дугаар зүйл буюу эрүүгийн мөрдөн шалгах ажиллагааг зогсоох үндэслэлүүдэд дээрх зарчмын процессын агуулгыг тусгасан. Тус зүйлд сэжигтэн, яллагдагчид холбогдуулан хийгдэж байгаа мөрдөн шалгах ажиллагаа нь дараах үндэслэлээр дуусгавар болно. Үүнд:

1. Сэжигтэн, яллагдагчид холбогдуулан тухайн гэмт хэрэгт ял оногдуулсан шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр, эсхүл тухайн гэмт хэргийг хэрэгсэхгүй болгосон шүүгчийн захирамж, тодорхойлолт гарсан.
2. Сэжигтэн, яллагдагчид холбогдуулан гаргасан эрүүгийн гэмт хэргийг хянан шалгахыг зогсоосон, эсхүл хэрэг үүсгэхээс татгалзсан мөрдөн шалгах байгууллага, мөрдөгч, прокурорын хүчин төгөлдөр шийдвэр байгаа.

Өөрөөр хэлбэл, *ne bis in idem* зарчмын хэрэгжилт зөвхөн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрээр хэрэгжих бус хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гарч буй урьдчилан хянан шалгах байгууллагын эрүүгийн мөрдөн шалгах ажиллагааг дуусгавар

⁴¹ 1996 оны 6 дугаар сарын 13-ны өдөр хүчин төгөлдөр болсон. 2020 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр сүүлийн нэмэлт, өөрчлөлт орсон.

⁴² 1996 оны 6 дугаар сарын 13-ны өдөр хүчин төгөлдөр болсон. 2020 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр сүүлийн нэмэлт, өөрчлөлт орсон.

болгож буй шийдвэр, тогтоолоор хэрэгждэг болохыг харж болохоор байна⁴³. Түүнчлэн, 2001 онд хууль санаачлагчид ОХУ-ын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 405 дугаар зүйлд «Дахин хянах байдлаар яллах шийдвэрийг авч үзэх, оногдуулсан ял хөнгөдсөн гэж үзсэн, эсхүл бусад шалтгаанаар гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрх зүйн байдлыг дордуулсан, илүү хүнд гэмт хэргээр яллах тухай шүүхийн тогтоол, шийдвэр, түүнчлэн цагаатгах шүүхийн тогтоол, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг зогсоох тухай шүүгчийн захирамж, шийдвэрийг дахин хянан хэлэлцэх боломжгүй» гэсэн заалтыг оруулсан. Тус улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг боловсруулагчид эрх зүйн байдлыг дордуулахыг хориглосон энэ заалтыг хуульчилснаар гэмт этгээдийг нэг гэмт хэрэгт дахин ял оногдуулах асуудал бүр мөсөн арилна хэмээн үзэж байжээ.

Харин хууль хэрэгжүүлэх практик нь энэхүү заалтын сул талыг илрүүлэн харуулсан байна. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (ЭХХШТХ)-ийн 405 дугаар зүйл нь эрүүгийн мөрдөн байцаах байгууллага болон шүүхийн гаргасан алдааг залруулахад саад тотгор учруулж эхэлсэн юм. Тухайлбал, хэргийг шийдвэрлэсэн байдлыг хүлээн зөвшөөрөөгүй хохирогч талын хувьд тэдний гомдол нь яллагдагч талын эрх зүйн байдлыг дордуулахуйц байгаа тохиолдолд хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэрт гомдол гаргах эрхгүй болсон билээ. Энэхүү нөхцөл байдал нь ЭХХШТХ-ийн 405 дугаар зүйлийг маш их шүүмжлэлд хүргэжээ. Хуулийн 405 дугаар зүйлийг анхлан санаачлагч нарын хувьд яллагдагчийн эрх зүйн байдлыг дордуулахын тулд шүүхийн эцсийн шийдвэрт гомдол гарган маргах асуудал нь өөрөө *ne bis in idem* зарчмыг зөрчсөн явдал юм хэмээн тайлбарласан билээ.

Хуульч В.И.Радченко⁴⁴-ийн хувьд «шийдвэрийн агуулгыг буюу ялыг хүндрүүлэх зорилгоор шүүхийн шийдвэрийг хүчингүй болгуулах нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг

⁴³ «Нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн *non bis in idem* зарчмын ОХУ-ын эрүүгийн процесс дахь хэрэгжилт», И.С.Дикарев, Волгоградын Улсын их сургуулийн эрхлэн гаргадаг сэтгүүл, 5 дахь цуврал, 2013 он, дугаар 1, хуудас 101.

⁴⁴ ОХУ-ын гавьяат шүүгч, хуульч. ОХУ-ын Засгийн газрын дэргэдэх Хууль тогтоомж, харьцуулсан эрх зүйн хүрээлэнгийн төвийн дарга

сэргээсэн, яллагдагчид нэг гэмт хэрэгт нь дахин ял оногдуулсан, ОХУ-ын Үндсэн хуулийн 50 дугаар зүйлийн 50.1 дэх хэсгийг зөрчсөн үйлдэл болно» хэмээжээ⁴⁵. Гэвч энэ байр суурь нь 1950 оны 11 дүгээр сарын 4-ний өдрийн Хүний эрхийн тухай Европын Конвенцын 7 дугаар протоколын 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсгийн агуулгатай харшилдаж байгаа юм. Тус протоколын 4.2-т *ne bis in idem* зарчмыг хэрэглэж байгаа нөхцөл нь хэрэгт холбоотой шинэ нөхцөл байдал илэрсэн, эсвэл өмнөх хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад хэргийн шийдвэрт нөлөөлөхүйц ноцтой алдаа гарсан тохиолдолд холбогдох улсын эрүүгийн болон эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу хэргийг дахин хянах боломжтой» хэмээн заасан байна⁴⁶.

Дээрх заалтад үндэслэн ОХУ-ын Үндсэн хуулийн шүүх 2005 оны 5 дугаар сарын 11-ний №5-П дугаар тогтоолоор «хохилогч (түүний төлөөлөгч)-ийн гомдол, эсвэл прокурорын танилцуулснаар хянан шалгах шатны байгууллага эрх зүйн байдлыг дордуулахгүй байх үүднээс хандаж байгаа нь хэргийг буруу хянан шийдвэрлэсэн өмнөх шийдвэрт гаргасан ноцтой алдааг залруулах боломжийг олгохгүй байгаа юм» хэмээн үзээд ЭХХШТХ-ийн 405 дугаар зүйл нь ОХУ-ын Үндсэн хуульд нийцээгүй гэж үзжээ.

Шүүхийн хүчин төгөлдөр шийдвэрийг хүчингүй болгоно гэдэг нь түүнийг цуцалж байгаа гэсэн үг бөгөөд хүчингүй болгосны дараагаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулах, эрүүгийн хариуцлагад татах, таслан сэргийлэх арга хэмжээ авах зэрэг нь дахин хянан үзэж байгаад тооцогдохгүй юм. Хүний эрхийн Европын шүүхийн тайлбарласнаар шүүхийн анхны шийдвэрийг хүчингүй болгосон тохиолдолд дараагийн шийдвэр нь тухайн эрүүгийн гэмт хэрэгтэй холбогдон гарсан цор ганц шийдвэр болно гэж дурджээ⁴⁷.

⁴⁵ «Нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн *non bis in idem* зарчмын ОХУ-ын эрүүгийн процесс дахь хэрэгжилт», И.С.Дикарев, Волгоградын Улсын их сургуулийн эрхлэн гаргадаг сэтгүүл, 5 дахь цуврал, 2013 он, дугаар 1, хуудас 102.

⁴⁶ https://www.echr.coe.int/Documents/Convention_ENG.pdf

⁴⁷ «Нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн *non bis in idem* зарчмын ОХУ-ын эрүүгийн процесс дахь хэрэгжилт», И.С.Дикарев, Волгоградын Улсын Их Сургуулийн эрхлэн гаргадаг сэтгүүл, 5 дахь цуврал, 2013 он, дугаар 1, хуудас 103.

Холбооны Бүгд Найрамдах Герман Улс

Өндөр хөгжилтэй ардчилсан орнуудын жишээнээс харахад, шинээр илэрсэн нөхцөл байдлын үндсэн дээр хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэрийг дахин хянах, ингэхдээ яллагдагч эсвэл гэм буруугүй нь тогтоогдсон этгээдийн эрх зүйн байдлыг дордуулсан буюу ялыг хүндрүүлсэн шийдвэрийг онцгой тохиолдлуудад л гаргахаар зохицуулсан байдаг.⁴⁸

Тухайлбал, Холбооны Бүгд Найрамдах Герман Улс (ХБНГУ)-ын ЭХХШТХ-ийн 362 дугаар зүйлийн дагуу хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэртэй хэргийг дахин хянах ажиллагаа нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийн эрх зүйн байдлыг дордуулж байгаа тохиолдолд зөвхөн дараах үндэслэлээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг сэргээж болно хэмээн заажээ. Үүнд:

- a. Шүүхэд гаргаж өгсөн баримт материал хуурамч байх;
- b. Гэрч эсвэл шинжээч тангаргаа зөрчих;
- c. Шүүгч албан үүргийн хувьд эрүүгийн хариуцлага хүлээх буруутай гэдгээ хүлээн зөвшөөрөх;
- d. Гэм буруугүй нь тогтоогдсон этгээд өөрийн гэм бурууг хүлээн зөвшөөрөх.

Бүгд Найрамдах Франц Улс

Non bis in idem зарчмын орчин үеийн ойлголтод хамгийн дөхсөн ойлголтыг Бүгд Найрамдах Франц Улс (цаашид «Франц Улс» гэх) анх 1791 оны Үндсэн хуулийн 9 дүгээр зүйлээрээ хуульчилж өгсөн юм. Тус 9 дүгээр зүйлд «Хуулийн дагуу бүрэлдсэн шүүх бүрэлдэхүүний шийдвэрээр цагаатгагдсан аливаа этгээд тухайн гэмт хэрэгтэйгээ холбогдуулан дахин хариуцлага хүлээх, яллагдах боломжгүй» хэмээн заажээ. Тус заалтын найруулга эрүүгийн эрх зүйн бодлогод илүүтэй сөрөг үр дагавар авчирсан гэж хэлж болно. Учир нь энэхүү томьёоллоор хэрэгт шинээр илэрсэн

⁴⁸ ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхийн 2007 оны 5 дугаар сарын 16-ны өдөр гаргасан N 6-П дугаар тогтоолд зориулж гаргасан ОХУ-ын Үндсэн хуулийн шүүхийн шүүгч С.М.Казанцев-ын тусгай санал. <http://www.consultant.ru/cons/cgi/online.cgi?req=doc&base=LAW&n=68552&fld=134&dst=100050,0&rnd=0.3312274249510827#09436271504196192>

нөхцөл байдал гарсан хэдий ч, тэдгээр нь тухайн этгээдийг гэмт хэрэг хийсэн гэдгийг нотлохуйц байсан ч нэгэнт гэм буруугүй гэж тогтоогдсон этгээдийн хэргийг сэргээх боломжгүй болгосон юм. Тус шалтгаантай холбогдуулан 1793 болон дараах онуудад нь батлагдсан Үндсэн хуулиудад тус зарчмын агуулга багтаагүй байх магадлалтай⁴⁹.

Франц Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 622 дугаар зүйлд «гэмт хэрэг үйлдсэн этгээдийн гэм бурууг тогтоон шийдвэр гарсны дараа шийдвэр гаргах үед ил болоогүй буюу мэдэгдээгүй байсан шинэ нөхцөл байдал илэрсэн бөгөөд яллагдагчийн гэм буруутай эсэхэд эргэлзээ төрүүлэхүйц байвал зөвхөн гэм буруутайд тооцогдсон этгээдэд ашигтай байх тохиолдолд шүүхийн эцсийн шийдвэрийг дахин хянаж үзэх тухай гомдлыг гаргах боломжтой» хэмээн хуульчилж өгчээ.

⁴⁹ <https://center-bereg.ru/o916.html>

ДҮГНЭЛТ

1. Манай улсын хувьд Эрүүгийн хуулийн шинэчлэлээр 2015 оны Эрүүгийн хуулийн ерөнхий ангид туссан зарчмуудын агуулгыг Олон улсын Эрүүгийн шүүхийн Ромын дүрэмд заасан агуулгаар шинээр томъёолж, «Шударга ёсны зарчим»-ын хүрээнд *ne bis in idem* буюу «нэг гэмт хэрэгт нэг удаа ял шийтгэх» тухай агуулгаар өөрчлөн баталжээ. Гэвч хуулийн төслийн үзэл баримтлал, ерөнхий ангид туссан зарчмыг тусгай ангид тодорхойлсон 2 гэмт хэргийн хувьд гажуудуулсан байна.
2. Шинэчилсэн Эрүүгийн хуулийн ерөнхий ангид *ne bis in idem* зарчмын агуулга тусгалаа олсон боловч нэгэнт тусгай ангид «урьд нь энэ бүлэгт заасан гэмт хэрэг үйлдэж гэм буруутайд тооцогдож байсан хүн» уг гэмт хэргийг үйлдсэн тохиолдолд ял шийтгэлийг хүндрүүлэн ногдуулахаар заасан байх тул шүүх уг заалтыг баримтлан гэм буруутай этгээдэд шийтгэл ногдуулж байна.
3. Монголын Хуульчдын Холбооны Эрүүгийн эрх зүйн хорооны хуульчид (шүүгч, прокурор, өмгөөлөгч, багш, судлаач гэх мэт) Олон улсын гэрээ, конвенцод *ne bis in idem* буюу «нэг гэмт хэрэгт нэг удаа ял шийтгэх» шударга ёсны зарчим байдаг гэдгийг мэдэх боловч энэхүү зарчим Монгол Улсын Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүнд заасан зохицуулалттай нийцэх эсэх талаар нэгдсэн байр суурийг илэрхийлж чадахгүй байна. Өөрөөр хэлбэл, *ne bis in idem* зарчмын ойлголт, агуулгыг хуульчдад сурталчлан таниулах шаардлага тавигдаж байна.
4. *Ne bis in idem* зарчим нь Монгол Улсын Үндсэн хуульд үгчлэн тусгагдаагүй, харин «шударга ёс»-ны зарчмын агуулгад тусгалаа олжээ. Харин Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Франц Улс Үндсэн хуульдаа *ne bis in idem* зарчмын

агуулгыг «нэг гэмт хэрэгт нэг удаа ял шийтгэх» буюу «нэг гэмт хэрэгт хоёр удаа ял шийтгэхгүй байх» агуулгаар тодорхой тусгасан байна. Улмаар уг зарчмын агуулгыг Эрүүгийн хууль, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулиудаар нарийвчлан баталгаажуулжээ.

САНАЛ

1. *Ne bis in idem* зарчмыг Үндсэн хуульд шууд утгаар тусган баталгаажуулах нь нэг гэмт хэрэгт давхардуулан эрүүгийн хариуцлага хүлээлгэх хэм хэмжээг батлахгүй байх, Үндсэн хуулийн хамгаалалтад оруулах боломжийг бүрдүүлнэ.
2. Олон улсын гэрээ, конвенцоор хүлээн зөвшөөрсөн *ne bis in idem* болон Эрүүгийн хуулийн шударга ёсны зарчмуудад нийцүүлэх үүднээс Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.1 дүгээр зүйлийн 2.7 болон 12.3 дугаар зүйлийн 2.2-д заасан «урьд нь энэ бүлэгт заасан гэмт хэрэг үйлдэж гэм буруутайд тооцогдож байсан хүн» гэсэн зохицуулалтыг хүчингүй болгох нь зүйтэй байна.
3. Мөн *ne bis in idem* зарчмын ойлголт, агуулгыг хуульчдад сурталчлан таниулах шаардлагатай.

--- оОо ---

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Хууль тогтоомж, конвенц

1. Монгол Улсын Үндсэн хууль
2. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пакт
3. Олон улсын Эрүүгийн шүүхийн Ромын дүрэм
4. Эрүүгийн хуулиуд (1986, 2002, 2015)

Үндсэн хуулийн цэцийн шийдвэр

1. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн гишүүний 2018 оны 10 дугаар сарын 08-ны өдрийн 161 дүгээр тогтоол

Ном, сэтгүүл, судалгааны тайлан

1. С.Нарангэрэл. Эрх зүйн эх толь бичиг. УБ., 2007 он.
2. Ч.Энхбаатар. Үндсэн хуулийн эрх зүй. УБ., 2007 он.
3. Д.Лүндээжанцан, Ч.Энхбаатар нар. Монгол Улсын Үндсэн хуулийн эрх зүй. УБ., 2000 он.
4. Г.Совд, Н.Жанцан нар. Монгол Улсын Үндсэн хуулийн тайлбар. УБ., 2000 он
5. Д.Баярсайхан. Эрх зүйн онол. УБ., 2010 он.
6. Г.Совд нар. Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар. УБ., 2000 он.
7. С.Жанцан. Монгол Улсын Эрүүгийн эрх зүйн онол. УБ., 2009 он.
8. Монгол Улсын Дээд шүүхийн Эрүүгийн эрх зүйн танхим, Ханнс Зайделийн сан, Эрх зүйн боловсрол академи. Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар. УБ., 2013 он.
9. Ж.Авхиа, Б.Ганболд нар. Монгол Улсын Эрүүгийн хуулийн тайлбар. УБ., 2002 он.
10. Э.Батбаяр «Ял хүндрүүлэх тухай маргааны зарим асуудалд» өгүүлэл 2 дахь талд, <http://legaldata.mn/buteel/pdf?id=66>

Гадаад хэл дээрх эх сурвалж

1. Международный пакт о гражданских и политических правах, 1966 г.
2. Конституция Российской Федерации, 1993 г.
3. Уголовный Кодекс Российской Федерации, 1996 г.

4. Уголовно-Процессуальный Кодекс Российской Федерации, 1996 г.
5. «Реализация общепризнанного принципа *non bis in idem* в Российском Уголовном Процессе», И.С.Дикарев, 2013 г.
6. Особое мнение судьи конституционного суда российской федерации С.М. Казанцева.
https://www.echr.coe.int/Documents/Convention_ENG.pdf
<http://www.consultant.ru/cons/cgi/online.cgi?req=doc&base=LAW&n=68552&fld=134&dst=100050,0&rnd=0.3312274249510827#09436271504196192>
<https://center-bereg.ru/o916.html>
<http://www.solon.org/Constitutions/Japan/English/english-Constitution.html>
<http://www.law.emory.edu/index.php?id=3080>
<https://criminal.findlaw.com/criminal-rights/the-concept-of-double-jeopardy-background.html#:~:text=In%20355%20B.C.%20Athenian%20statesmen,teachings%20of%20early%20Christian%20writers>
https://ru.wikisource.org/wiki/%D0%AD%D0%A1%D0%91%D0%95/Ne_bis_in_idem

Бусад

- <http://legalinfo.mn>
- <http://www.supremecourt.mn>
- <http://new.shuukh.mn>
- <https://mojha.gov.mn/newmojha>
- <http://legaldata.mn>

